



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/326

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Жендэрийн тэгш байдлыг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Охидыг цахим гэмт хэргээс сэргийлэх арга замууд” төслийн зардалд 8000 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 8000 000 төгрөг /найман сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 5.15-д тусгагдсан “Жендэрийн тэгш байдлыг хангах” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ